



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 70007734, Факс: (976-11) 32 01 54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2019.02.22 № 235

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН
ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ,
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Ц.ПҮРЭВДАШ ТАНАА

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018
оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан,
гэрчилгээг хүргүүлж байна.

Хавсралт: 30 хуудас.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



С.ЭНХБААТАР

D:\2019 on\Ywuulsan bichig\2019.02.22.Niisiel.Turgen.tuslamj.docx.A5

1110400235

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: НТАГ-2019/158/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2019 он	Захирал бөгөөд аудитын багийн ахлагч: Н.Цэрэнханд Утас: 99901517 Цахим хаяг: Khandnorov@yahoo.com Аудитын менежер: Д.Өлзийорших Утас: 99487799 Цахим хаяг: Ulzii@gmail.com Туслах аудитор: Б.Баярмаа Утас: 99020639 Цахим хаяг: Bayarmaa_0220@yahoo.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 70007734, Факс: (976-11) 32 01 54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2019.02.22 № 236

танай _____ -ны № _____ -Т

НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН
ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ, ТӨСВИЙН ШУУД
ЗАХИРАГЧ Ц.ПҮРЭВДАШ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\2019 on\Ywuulsan bichig\2019.02.22.Niisleiin.turgen.tuslamj.docx

1110400236

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



С.ЭНХБААТАР

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	13
4	аудит хийсэн санхүүгийн тайлан	16
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	16
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	18
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	20
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	22
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	23

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ц.Пүрэвдаш танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэгцтөв богд Аудит ХХК нь Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Нийслэл дэх төрийн аудитын газартай байгуулсан гурвалсан гэрээг үндэслэн санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 25-наас 2019 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, "Цэгцтөв богд аудит ХХК-ын аудитор Н.Цэрэнханд хариуцаж хэрэгжүүлэв.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нийслэлийн түргэн тусламжийн төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Цэгцтөв богд аудит” ХХК-д 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 02/34 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Нийслэлийн түргэн тусламжийн төв нь “...Мэргэжлийн болон ёс зүйн өндөр үр чадвар эзэмшсэн баг эмнэлэг хүртэлх түргэн тусламжийг цаг алдалгүй чанартай хүртээмжтэй хүргэх явдал юм” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл: Нийслэлийн түргэн тусламжийн төвийн чиг үүргийг Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2016 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/26 тоот тушаалаар батлагдсан дүрмэнд “нийслэлийн нутаг дэвсгэрийн төвийн 6 дүүргийн болон алсын дуудлагаар хүн амд газар дээр нь болон эмнэлэг хүртэлх түргэн тусламжийн үйлчилгээг оновчтой шуурхай хүргэх” гэж тодорхойлсон.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрх бүхий байгууллагаас гаргасан бусад холбогдох заавар, журам

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв. Үүнд:

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа гол хуульд нэмэлт өөрчлөлт ороогүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус төвийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Нийслэлийн түргэн тусламжийн төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.

Аудитын явцад Нийслэлийн түргэн тусламжийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 2.0 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Нийслэлийн түргэн тусламжийн төв нь төсвөөс санхүүжилт авч, төсвийг бүрэн зарцуулсантай холбоотой юм.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны нийт зардал 9,381,864.5 мянган төгрөг бөгөөд түүний 2.0 хувь болох 187,637.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг сонгосон суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2.0 хувиар тооцсон нь тухайн байгууллагын аудитын чиглэлүүдэд үзүүлж болзошгүй эрсдэлийг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшнийг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 15 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 8 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгээгүй.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	7	17,330.0	
2	Албан шаардлага	1	51,500.0	
	Дүн	8	68,830.0	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Балансын данстай холбоотой асуудал.

Шатахуун, сэлбэг хэрэгсэл худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй 51,500.0 төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ үзүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 5 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 7,409,760,2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт,

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 7,177,802.3 мянган төгрөг буюу 96.9 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой зардал 55,002.0 мянга, цалингийн зардал 36,313,4 мянга, хангамж бараа материалын зардал 2,518,4 мянган төгрөгөөр нийт 231,957,9 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Тус байгууллагын төсвийн шууд захирагч нь 2018 онд улсын төсвөөс 7,409,760,2 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төсөв батлагдсаныг бүрэн авч, үйл ажиллагааны урсгал зардалд 7,177,802.3 мянган төгрөг зарцуулж, зардал хэмнэснээс үлдсэн 231,957.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансаар НЭМГ-аас Улсын их баяр наадмын зардалд 3,000.0 мянга, Улаанбаатар хотын аялал, жуулчлалын газраас баяр наадмын зардалд 3,000.0 мянга, Улаанбаатар хотын нийтийн биеийн тамир спортын хорооноос Марфон гүйлтийн зардалд 1,000,0 мянга, Нүүдэлчин Монгол наадамд 3,192.0 мянга, Баяр наадмын комиссоос Улсын их баяр наадмын зардалд 2,100.0 мянга, НЭМГ-аас 2018 оны ажлын үзүүлэлтээр 2-р байрт шалгарсны шагналд 15,000.0 мянга, бүгд 27,292.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Нийслэлийн түргэн тусламжийн төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянахад мэдээллийг шилэн дансандаа бүрэн байршуулсаныг баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитыг НЭМГ-ын харьяа байгууллагуудын нэгдсэн тайлангийн түүврийн аудитад хамрагдсан бөгөөд өгсөн акт, зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100.0 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит



**НИЙСЛЭЛИЙН
ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1 дүгээр хороо, Чин ван Г. Чагдаржавын гудамж,
Утас/Факс: (976-11) 32 18 11, И-мэйл: nttt@103.ub.gov.mn,
Вэбсайт: www.103.ub.gov.mn

2019.02.21 № 02/65

тантай _____-ны № _____-т

ЦЭГЦ ТӨВ БОГД АУДИТ ХХК-Д

Манай байгууллагын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитаар ирүүлсэн зөрчилтэй асуудлын бүртгэлтэй танилцлаа.

Цаашид аудитын зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн анхаарч ажиллах болно.

Хавсралт 2 хуудастай.



ЗАХИРАЛ *Ц. Дүрэвдаш* Ц. ДҮРЭВДАШ

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Нийслэлийн түргэн тусламжийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт шинэчлэгдсэн хууль эрх зүйн актууд, стандартуудын өөрчлөлтүүдийг тусгаагүй. Энэ нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” заалтыг зөрчсөн.

3.1.2 Эрсдэл:

Хууль журам зөрчигдөх, бүртгэл тооцоо алдаатай хөтлөгдөх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ТШЗ-ийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй шинэчлэхээр ажиллаж байгаа талаар хариу ирүүлсэн.

3.2 Анхан шатны бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Анхан шатны бүртгэлийн маягтуудыг хүчингүй болсон маягтуудаар хөтөлж байна. Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн.

3.2.2 Эрсдэл:

Хууль журам зөрчигдөх, баримтын үнэн зөв байдал алдагдах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан маягтуудыг анхан шатны бүртгэл хөтлөлтдөө ашиглах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

ТШЗ-ийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй санхүүгийн программаар хөтөлдөг анхан шатны маягтуудыг шинэчилэн ажиллаж байгаа талаар хариу ирүүлсэн.

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Насжилт өндөртэй авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй тайлант хугацаанд шүүхэд хандаагүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалтыг зөрчсөн

3.3.2 Эрсдэл:

Хууль журам зөрчигдөх, авлага найвдаргүй болох, алдагдал хүлээх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Насжилт өндөртэй 10 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, шийдвэрлүүлэх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

ТШЗ-ийн зүгээс цаашид дахин шүүхэд хандаж авлагыг барагдуулах арга хэмжээг идэвхтэй авч хэрэгжүүлэх талаар хариу ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Хувь хүний орлогод ногдох албан татварт хөнгөлөлт үзүүлэх шатлалыг алдаатай тооцоноос 825.0 мянган төгрөг илүү суутгасан. Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараахь хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ:" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Авлага, ер төлбөр үүсэх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Ажиллагсдын цалингаас ХХОАТ-ын хөнгөлөлт тооцоход хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д зааснаар хөнгөлөлт үзүүлж, программаар тооцсон татварын хөнгөлөлтийг нягтлан бүртгэлд тусгаж байх

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Программд зөрүүтэй тусгасан байгаа программын шинэчлэл 2019 оны 01 дүгээр сард хийгдсэн цаашид алдааг давтан гаргахгүй талаар хариу ирүүлсэн.

3.5 Зардлын данстай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

Албан ажлын хэрэгцээнд хувийн авто машинаар ажил гүйцэтгэхэд олгох шатахууны норматив тогтоогоогүй, шатахууны талон олгож байна. Энэ нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2-т "албан ажлын хэрэгцээнд хувийн унаа хэрэглэсэн тохиолдолд батлагдсан нормативын дагуу гарсан зардлыг" олгож болно гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.5.2 Эрсдэл:

Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих боломж алдагдах, хөрөнгө үр дүнгүй зарцуулагдах

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Ажлын шаардлагаар хувийн машиныг албан хэрэгцээнд ашиглахад хуулинд заасны дагуу ажлын шаардлагыг тодорхойлж, зарцуулах шатахууны буюу мөнгөн хөрөнгийн норм хэмжээг тогтоож журамлах

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч цаашид алдааг давтан гаргахгүй норм хэмжээг тогтоож тушаалаар баталгаажуулан мөрдөж ажиллах талаар хариу ирүүлсэн.

3.6 Зардлын данстай холбоотой асуудал

3.6.1 Илрүүлэлт:

Шатахуун, сэлбэг хэрэгсэлийг шууд гэрээ байгуулан худалдан авалт хийж байгаа нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн" 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.6.2 Эрсдэл:

Хууль журам зөрчигдөх

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Сэлбэгийг худалдан авах болон зарцуулахад холбогдох журмыг баримтлан хяналт тавьж ажиллах

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

